

## ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖААНЫ ЖУРАМ

### 煤炭电子交易制度

#### Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

##### 第一条，总则

1.1.“Эрдэнэс Тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан Гашуунсухайт боомт дах Чингэлэгт тээврийн терминалаар нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын нүүрсийг цахимаар нээлттэй арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, нүүрсний чанарын шинжилгээ хийх, эдгээрт хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

本制度协调“Erdenes Tavantolgoi”股份公司和Gashuunsukhait口岸集装箱运输码头的其他煤炭出口商经过交易所组织公开电子交易、执行结算、煤炭质量检验、监控等方面的关系。

1.2.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

下列名词术语适用于本制度:

1.2.1.“цахим арилжаа” гэж экспортод гаргах нүүрсийг доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэй арилжих үйл ажиллагааг;

“电子交易”是指将拟出口的煤炭以最低价格通过电子交易公开拍卖方式进行的业务;

1.2.2.“худалдагч” гэж “Эрдэнэс Тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан Гашуунсухайт боомт дах Чингэлэгт тээврийн терминалаар нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийг;

“销售方”是指“Erdenes Tavantolgoi”股份公司和通过Gashuunsukhait口岸集装箱运输码头提出申请出口煤炭的企业;

1.2.3.“худалдан авах санал гаргагч” гэж нүүрс худалдан авахаар цахим арилжаанд оролцогч этгээдийг.

“发起者”是指有意购买煤炭的电子交易参与商;

1.2.4.“худалдан авагч” гэж цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарч, худалдагчтай экспортын гэрээ байгуулсан этгээдийг;

“采购方”是指通过电子交易购买煤炭，与卖方签约煤炭出口合同的;

1.2.5.“арилжаа зохион байгуулагч” гэж цахим системээр дамжуулан арилжаа зохион байгуулах хуулийн этгээд буюу Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийг;

“交易组织者”是指通过电子交易系统组织交易的法定代表或蒙古证券交易所国有控股公司;

1.2.6.“дэнчин” гэж худалдан авах санал гаргагчаас цахим арилжааны үүргийн гүйцэтгэлийн нотолгоо болгож худалдагчид төлбөл зохих төлбөрт оролцуулан арилжаа зохион байгуулагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкны нэрийн дансанд урьдчилан байршуулах мөнгөн хөрөнгийг;

“保证金”是指发起者在银行法第3.1.20条规定的交易组织者名下的银行账户中预存的资金，作为履约证据支付给销售方的适当款项;

1.2.7.“нүүрс нийлүүлэх цэг” гэж Монгол Улсын Гашуунсухайт боомт дахь Чингэлэгт тээврийн терминалыг;

“煤炭供应地点”是指蒙古国 Gashuunsukhait 口岸的集装箱运输码头;

1.2.8.“итгэмжлэгдсэн лаборатори” гэж Гаалийн төв лаборатори эсхүл Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийг;

“授权化验室”是指海关总署下属的海关中心化验室或国家授权的化验室;

1.2.9.“экспортын гэрээ” гэж цахим арилжааны системд амжилттай биелсэн хэлцлийн дагуу Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-иас баталсан загвараар байгуулах нүүрс экспортлох худалдааны гэрээг;

“出口合同”是指根据电子交易中成功达成的协议，以蒙古证券交易所批准的模式签约的煤炭出口合同;

## **Хоёрдугаар зүйл. Экспортын нүүрсний нээлттэй цахим арилжаа**

### **第二条，煤炭公开电子交易**

2.1.“Арилжаа зохион байгуулагч” нь MNS 6457:2022 “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлттэй нүүрсийг цахимаар арилжина.

“交易组织者”是符合 MNS 6457:2022 “煤炭、煤炭产品种类”标准中规定的种类、类别、质量指标等要求的煤炭应当通过电子交易系统形式进行交易;

2.2.Цахимаар арилжих нүүрсний нэг багц нь 6,400 тонн бөгөөд нэг удаагийн захиалгын дээд хэмжээ нь 25 хүртэл багц байна.

通过电子系统形式出售的煤炭批量吨数为6400吨/个，一次提交的订单上限为25个批量;

2.3.Худалдагч нь цахимаар арилжих нүүрсний захиалгыг дараах бүрдүүлбэрийн хамт арилжаа зохион байгуулагчид тухай бүр өгнө. Үүнд:

销售方应当将电子交易销售的煤炭订单交给交易组织者的同时提供下列文件。

2.3.1.цахимаар арилжаалах нүүрсний багцын тоо, тухайн багцад хамаарах нүүрсний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт

电子交易销售的煤炭批量吨数，该批量所属的煤种、煤类、质量指标

2.3.2.итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт /цахим/ 授权化验室的检验报告/电子形式/

2.3.3.дуудах доод үнэ, валютын төрөл.

拍卖最低价格，货币种类

2.4.Арилжаа зохион байгуулагч нь худалдагчаас ирүүлсэн тоо хэмжээг хэтрүүлэхгүйгээр, захиалгад заасан хэмжээгээр цахим арилжааг зохион байгуулна.

交易组织者按照订单规定的数量组织电子交易，不得超过销售方提交的数量。

2.5.Захиалгын бүрдүүлбэр хангаагүй захиалгыг бүртгэхгүй.

不符合要求的订单将不予注册。

## **Гуравдугаар зүйл. Цахим арилжааг зохион байгуулах**

### **第三条，组织电子交易**

3.1.Арилжаа зохион байгуулагч нь цахим арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг хангасан байдлаар цахимаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, арилжаалагдаж буй нүүрсний үнэ, гэрээний мэдээллийг арилжаанд оролцогчид болон олон нийтэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх, арилжааны хэлцлийн үр дүнд үүссэн төлбөрийн үүргийг тодорхойлон бүртгэх, экспортын гэрээ байгуулах, төлбөрийг найдвартай гүйцэтгэх нөхцөлийг хангаж ажиллана.

交易组织者以公开、透明的方式组织电子交易，保证参与者的公平权利，设定实际市场价格、交易煤炭价格，应将合同信息准确、快速传递给交易参与者和公众，明确记录电子交易产生的付款义务，签订出口合同，满足可靠付款的条件。

3.2.Худалдагч нь худалдах нүүрсний захиалгыг арилжаа зохион байгуулагчид арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө өгсөн байна.

销售方至少 7 个工作日之前向交易组织者提交出售的煤炭订单。

3.3.Арилжаа зохион байгуулагч нь энэ журмын 3.2-т заасан захиалгын бүрдлийг ажлын 2 өдрийн дотор шалгаж, шаардлага хангасан гэж үзвэл захиалгын дагуу цахим арилжааны зарыг өөрийн албан ёсны цахим хуудаст арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө байршуулна.

交易组织者应在 2 个工作日内对本制度第 3.2 条中规定的订单情况进行审核，如符合条件的，按照订单至少 5 个工作日之前在其官方网站上发布电子交易公告。

3.4.Цахим арилжааны зард дараах зүйлсийг тусгана:

电子交易公告有如下内容:

3.4.1.цахим арилжаа зохион байгуулах хугацаа;

电子交易组织时间

3.4.2.нүүрсний багцын тоо, чанар, стандарт;

煤炭销售批量数，质量指标，标准

3.4.3.нүүрс нийлүүлэх цэг /Гашуунсухайт боомт дахь Чингэлэгт тээврийн терминал/;

煤炭供应地点/Gashuunsukhait 口岸集装箱运输码头

3.4.4.нүүрс хүргэж өгөх хугацаа;

煤炭送运期限

3.4.5.нүүрс татан авах хугацаа;

拉煤期限

3.4.6.дуудах доод үнэ, валютын төрөл;

拍卖最低价格，货币种类

3.4.7.дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн;

拍卖时加价最低数额

3.4.8.дэнчингийн хэмжээ, төлөх нөхцөл, дэнчин байршуулах дансны дугаар, валютын төрөл;

保证金金额，付款条件，保证金预存银行账户，货币种类

3.4.9.цахим арилжаанд оролцох заавар;

参与电子交易的说明

3.4.10.мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар.

工作人员的联系方式，电话号码

3.5.Худалдан авах санал гаргагч нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө Арилжаа зохион байгуулагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд дахь дансанд дэнчинг байршуулснаар цахим арилжаанд оролцох эрх үүснэ.

发起者在交易开始前至少 30 分钟之前将保证金存入交易组织者银行法第 3.1.20 条规定的银行账户，即生效参与电子交易。

3.6.Цахим арилжааны системд амжилттай биелснээс хойш ажлын 7 өдрийн дотор Худалдагч болон Худалдан авагч нар арилжаа зохион байгуулагчаас баталсан загварын дагуу экспортын гэрээг баталгаажуулан арилжаа зохион байгуулагчид ирүүлэх ба Худалдан авагч нь хэлцлийн төлбөрийг 100% /дэнчинг хассан дүнгээр/ худалдагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд дахь нэрийн дансанд байршуулна. Арилжаа зохион байгуулагч нь экспортын гэрээнд үндэслэн дэнчинг худалдагчийн нэрийн данс руу ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.

在电子交易系统成功完成交易后 7 个工作日之内，购销双方按照交易组织者认可的合同模式确认煤炭出口合同而送至交易组织者，采购方应当支付 100%的交易货款/减去保证金/根据销售方银行法第 3.1.20 条规定将其存入银行账户。交易组织者根据煤炭出口合同，在 5 个工作日之内将保证金转入销售方名下账户。

3.7.Цахим арилжаанд оролцох дэнчингийн хэмжээ нь доод үнээр илэрхийлсэн тухайн захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

参与电子交易的保证金金额等于以最低价格的订单总额的 10%。

3.8.Цахим арилжааны арга, ашиглах нөхцлийг дараах байдлаар тогтооно:

电子交易进行的方法，使用条件如下：

3.8.1.нүүрсний багцын дуудах доод үнийг худалдагч тал захиалгад тусгасан байна;

销售方必须在合同中提出煤炭批量拍卖叫价的最低价格；

3.8.2.цахим арилжааны үед хэлцэл хийгдэх хүртэл үлдэж байгаа хугацааг секундээр тооцон арилжаанд оролцогчид харуулна;

在电子交易过程中的剩余时间以秒为单位显示给交易参与者；

3.8.3.цахим арилжаа нь захиалга бүртгэх үе, дуудах үе, хэлцэл хийгдэх үе гэсэн 3 үе шаттайгаар явагдана.

电子交易分成三个阶段：订单注册阶段、拍卖阶段和交易阶段。

3.8.4.худалдан авах анхны захиалга бүртгэх үе нь 60 минут хүртэл хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед захиалгыг өөрчлөх эсхүл цуцалж болно.

第一笔采购订单注册时间最长为 60 分钟，当时可以更改或取消订单。

3.8.5.дуудах үе нь 1 минутын хугацаанд үргэлжилнэ. Дуудах үед шинээр захиалга оруулах, тоо ширхгийг өөрчлөх болон үнийг бууруулан захиалгад өөрчлөлт оруулахыг хориглох бөгөөд зөвхөн арилжааны системд бүртгэгдсэн захиалга дуудах үед оролцон үнэ хаялцах эрхтэй.

拍卖叫价时间为 1 分钟。拍卖叫价时禁止新增订单、更改数量或降低价格，只能在交易系统中已注册的订单叫价时有权参与讨价。

3.8.6. дуудах үед үнэ шинэчлэгдсэн тохиолдол бүрт энэ зүйлийн 3.8.5-д заасан 1 минутын дуудах үеийн хугацаа эхлэн тооцогдоно.

拍卖叫价过程当每次价格更新，按照本条第 3.8.5 款中指定的 1 分钟叫价时间重新计算。

3.8.7. сүүлийн үнийн өөрчлөлт орсноос хойш 1 минутын хугацаанд дахин өөрчлөлт ороогүй тохиолдолд хэлцэл хийгдсэнд тооцно.

价格更新后 1 分钟之内价格再次没有更新的，视为成交。

3.9. Арилжаа зохион байгуулагч нь нүүрсний цахим арилжааны мэдээ, тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлнэ.

交易组织者应当通过其官方网站及时向社会公开公布煤炭电子交易的新闻报道。

3.10. Биржийн арилжааны шимтгэл нь арилжааны үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцүү байна.

交易所收取的交易手续费等于交易金额的 0.1%。

3.11. Арилжаа зохион байгуулагч нь цахим арилжааны системтэй холбоотой сургалтыг шаардлагатай тохиолдолд өөрийн санаачилгаар болон сонирхогч этгээдийн хүсэлтээр зохион байгуулж болно.

交易组织者根据需要主动或者有意者的要求，可以组织电子交易系统有关的培训。

## **Дөрөвдүгээр зүйл. Төлбөр тооцоо**

### **第四条， 结算**

4.1. Худалдан авагч нь энэ журмын 3.6-д заасны дагуу байгуулсан экспортын гэрээнд үндэслэн хэлцлийн төлбөрийг ажлын 7 өдрийн дотор худалдагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкн дахь нэрийн дансанд байршуулна.

根据本制度第 3.6 条款签订的煤炭出口合同，采购方应在 7 个工作日之内将交易货款存入银行法第 3.1.20 条款中指定的销售方银行账户。

4.2. Арилжаа зохион байгуулагч нь дэнчинг энэхүү журмыг зөрчиж аливаа этгээдэд шилжүүлэх, барьцаалахыг хориглоно.

交易组织者不得违反本制度将保证金转让或质押给任何人。

4.3. Арилжаа явагдаагүй тохиолдолд тухайн арилжааг төвлөсөн өдрөөс хойш, арилжаанд оролцоогүй эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа явагдсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор арилжаа зохион байгуулагч нь худалдан авах санал гаргагчид дэнчинг тус тус буцаан олгох бөгөөд банкны гүйлгээний шимтгэлийг арилжаа зохион байгуулагч хариуцахгүй.

如未进行拍卖交易的，预定交易之日起，如未参与拍卖交易的，或参与交易但未应价的，交易组织者应在 5 个工作日之内将保证金退还发起者，交易组织者不承担银行汇款手续费。

4.4. Энэ журмын дагуу Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим арилжаагаар Монгол Улсын Гашуунсухайт боомт дах Чингэлэгт тээврийн терминал нөхцлөөр худалдан борлуулсан нүүрсэнд татвар, төлбөр, хураамжийг экспортод гаргасан нүүрсний зохицуулалтын дагуу ногдуулна.

根据本制度，通过蒙古证券交易所的电子交易形式出售 Gashuunsukhait 口岸集装箱运输码头的煤炭按照煤炭出口管理应缴纳出口税、手续费。

4.5. Цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарсан этгээд нь хэлцэл амжилттай хийгдсэн боловч хэлцлийн төлбөрийг хугацаандаа эсхүл бүрэн шилжүүлээгүй, журмын 3.6-д заасны дагуу экспортын гэрээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр байгуулахаас татгалзсан, энэхүү журмыг зөрчиж арилжаанд оролцсон тохиолдолд худалдагчийн хүсэлтээр арилжаа зохион байгуулагч нь тухайн хэлцлийг цуцалж, дэнчинг худалдагчийн орлого болгоно.

通过电子交易方式应价者已成功完成交易，但未按时支付交易货款或者未支付全部货款，依照本制度第 3.6 条款规定无正当理由拒绝不签订出口合同的，或者违反本制度参与交易的，交易组织者应当根据销售方的要求取消交易，并收取保证金，作为销售方的收入。

4.6. Энэ журмын 4.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд худалдагч нь тухайн цуцлагдсан хэлцлийн захиалгаа арилжаа зохион байгуулагчид шинэчлэн хүргүүлнэ.

如果发生本制度第 4.5 条款中规定的情形，销售方应当向交易组织者重新提交取消交易的订单。

4.7. Цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарсан этгээдийн хэлцлийн төлбөрийн үнийн дүнд дэнчинг оруулан тооцно.

通过电子交易方式应价者的应付交易货款中扣除保证金。

## **Тавдугаар зүйл. Худалдагч**

### **第五条，销售方**

5.1. Худалдагч нь энэхүү журмын 3.4-т заасан цахим арилжааны зарыг арилжаа зохион байгуулагчид урьдчилан хүргүүлнэ.

销售方应将本制度第 3.4 条款中规定关于电子交易方面的公告信息提前提供给交易组织者。

5.2. Шаардлагатай тохиолдолд арилжаа зохион байгуулагч эсвэл арилжаанд оролцогчийн шаардлагаар арилжаалах нүүрсний талаар нэмэлт мэдээлэл өгч болно.

必要时，应按照交易组织者或交易参与方的要求，提供有关交易煤炭的补充信息。

5.3. Худалдагч нь төлбөр тооцоонд цахим төлбөрийн баримт үйлдэж, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хэлцлийг бүртгэнэ.

销售方将出具电子支付收据进行结算，并在税务登记和数据库中进行交易登记。

## **Зургаадугаар зүйл. Худалдан авах санал гаргагч**

### **第六条，发起者**

6.1. Гадаад болон дотоодын хуулийн этгээд нь цахим системд бүртгүүлж худалдан авах санал гаргагчаар арилжаанд оролцоно.

国内外法人应在电子交易系统上注册并作为发起者名义参与交易。

6.2.Худалдан авах санал гаргагч нь журмын 6.1-д заасан цахим системд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

发起者在本制度第 6.1 条款中指定的电子交易系统上注册时应提供下列文件。

6.2.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

营业执照

6.2.3.Оршин суугаа улсын татвар төлөгчийн гэрчилгээ, татвар төлөгчийн дугаар;

居住国家税务登记证, 税务登记证编号,

6.2.4.Харилцагч банкны дансны тодорхойлолт

银行账户信息

6.2.5. Гадаад хэл дээрх баримт бичгийг Англи хэл дээрх албан ёсны орчуулгын хамт

如有外语文件, 附上正式英文版本

6.3.Худалдан авах санал гаргагч нь бусад этгээдтэй үгсэн хуйвалдах, харилцан тохиролцох замаар цахим системээр арилжигдах нүүрсний үнийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглах зорилгоор аливаа үйлдэл хийхийг хориглоно.

发起者不得相互串通, 人为设定电子系统煤炭交易价格, 操纵市场价格行为。

6.4.Худалдан авах санал гаргагч нь энэхүү журмын 6.3-т заасан үйлдэл хийсэн тохиолдолд арилжаа зохион байгуулагч цахим системд 6-12 сарын хугацаанд дахин бүртгэхгүй байх арга хэмжээ авна.

发起者有本制度第 6.3 条款规定行为的, 交易组织者应当采取措施, 停止 6-12 个月期间电子交易系统中重新注册。

## Долоодугаар зүйл. Итгэмжлэгдсэн лаборатори

### 第七条, 受权化验室

7.1.Цахимаар арилжаалах нүүрсний чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийнэ

受权化验室负责完成电子交易的煤炭质量检验。

7.2.Итгэмжлэгдсэн лаборатори нь хараат бусаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллана.

受权化验室根据有关法律法规独立完成业务。

7.3.Арилжаа зохион байгуулагч нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээг хүлээн авснаар цахим арилжааг зохион байгуулна.

交易组织者应收到受权化验室的检验报告后组织电子交易。

7.4.Худалдагч, худалдан авагч талууд экспортын гэрээнд заасны дагуу шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатороор шинжилгээ хийлгэж болно.

购销双方根据出口合同如有需要, 可以委托第三方化验室/机构完成检验。

## Наймдугаар зүйл. Тээвэрлэлт

## 第八条，运输

8.1. Гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийг худалдагч тал хариуцна.  
报关手续由采购方负责。

8.2. Худалдагч нь нүүрс нийлүүлэх цэг хүртэлх тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотой эрсдэлийг хариуцна.

销售方承担煤炭运至煤炭供应低点的运输和运输有关的风险。

8.3. Нүүрс нийлүүлэх цэгээс цааш гарах тээвэрлэлтийг худалдан авагч хариуцна.  
采购方负责煤炭供应地点以外的运输。

## Есдүгээр зүйл. Хяналт

### 第九条，监督

9.1. Энэ журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.  
金融协调委员会将对本制度的执行过程实施监督。

## Аравдугаар зүйл. Хариуцлага

### 第十条，责任

10.1. Худалдагчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас бусад түүний буруутай үйл ажиллагааны улмаас экспортын гэрээнд заасан хугацаанд зохих нүүрсийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй нүүрсний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө.

因非销售方真实的意愿，约定的煤炭未能在出口合同规定的期限内全部运抵交货地点，每延误一天，销售方按煤炭出口合同总额的 0.1% 违约金支付给采购方。

10.2. Худалдан авагч нь экспортын гэрээнд заасан хугацаанд худалдан авсан нүүрсээ нүүрс нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй нүүрсний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.

采购方未在出口合同规定的期限内将购入的煤炭全部从交货地点拉运，每迟延一天，采购方按煤炭出口合同总额的 0.1% 违约金支付给销售方。

10.3. Цахим арилжаа зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан харилцааг энэхүү журмын 1.2.5-т заасан этгээдийн журам, заавраар зохицуулна.

电子交易组织有关的详细关系应当按照本制度第 1.2.5 条款中指定的法定人规章制度进行协调。

## Арваннэгдүгээр зүйл. Бусад

### 第十一条，其他

11.1. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.  
本制度自批准之日起生效。



11.2. Энэхүү журмаар зохицуулсан харилцааг тусгайлан зохицуулсан хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнээр энэхүү журам хүчингүй болно.

应将本制度协调的关系由专门的法律生效后废除本制度。

11.3. Худалдагч, худалдан авагч нарын хооронд үүсэх маргааныг талууд өөрөөр тохиролцоогүй бол Монгол Улсын Олон улсын Арбитраар шийдвэрлүүлж болно.

购销双方之间发生争议的，双方未另作约定，可以申请蒙古国国际仲裁法庭解决。

--o0o--